



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 432

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

“Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн ИТХурлын “Баяр наадам зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах” тухай 2017 оны 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр хот үүсгэн байгуулагдсаны 290 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотод болох Өвөрхангай аймгийн нутгийн зөвлөлийн золголт арга хэмжээнд шаардлагатай төсвийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах бүгд 818550 /Найман зуун арван найман мянга таван зуун тавь/ төгрөгийг Орон нутгийн нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч /М.Отгон/-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

14 0063

Сумын Засаг даргын 2017 оны
03 дугаар сарын 22 ны /ний/ өдрийн
01 дугаар /дүгээр/ захирамжийн хавсралт
02.



УЛААНБААТАР ХОТОД БОЛОХ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН
ЗОЛГОЛТ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

№	Зарцуулах зүйлийн нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Айраг	80 л	2500	200000
2	Хонь	1 ш	200000	200000
3	Цэвэр ус	34 ш	1000	34000
4	Ааруул	3 кг	13000	39000
5	Мандат	10 ш	500	5000
6	Анонс	1	46000	46000
7	Арвайхээр хотын танилцуулга	300	500	150000
8	Бусад /боорцог, үрэл, самар, ёотон, сальфетика, цай/		144550	144550
НИЙТ ДҮН				818550

-----oOo-----